САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ТАВДУГААР САР 2020

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
-10.7%
2020 оны I-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
3.3%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2797.25 төг

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ
-1490 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
13.9 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3556 САЯ АМ.ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.4%

НИЙТ ХАДГАЛАМЖ
14.6 ИХ НАЯД ТӨГ

МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
30.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
974.1 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
9%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: 2.1%,
Инфляци: 2020 онд: 6.6%,
Урсгал тэнцэл: 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2XR5XVj

ДНБ-ий өсөлт: 2020 онд: -1%
Инфляци: 2020 онд: 5.6%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: -10.2%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: https://bit.ly/2XR5XVj

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ТАВДУГААР САР 2020

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 5-р сарын байдлаар (1490) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 15.4 хувиар буурч, зарлага 27 хувиар нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1490 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 1636 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 14.05 төгрөгөөр өсөв.

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 152 төгрөг буюу 5.7 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 14.05 төгрөг буюу 0.50 хувиар, өмнөх улирлаас 1.48 хувиар өсч 2797.25 төгрөг болов. 5-р сард гадаад валютын нөөц 3.5 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 11 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар, оны эхнээс 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Инфляцийн түвшин 3.3%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 5-р сарын байдлаар өмнөх сараас 0.1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар, оны эхнээс 2.4 хувь өсөв. Үүнд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.



Гадаад худалдааны тэнцэл 13.9 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны тавдугаар сард нийт барааны эргэлт 3998 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 28.3 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 38.5, импорт өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 13.9 сая ам.долларын ашигтай гарав.



5-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ



Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5-р сард өмнөх сараас 0.2 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буурч 17.1 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1972 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 5.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буурсан байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11.5% байна.

САРЫН ОНЦЛОХ

МОНГОЛ УЛСАД 99 САЯ АМ.ДОЛЛАРЫН ШУУРХАЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОХ БОЛОВ.

- ОУВС-гийн ажлын баг Монгол Улсыг Covid-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх Шуурхай санхүүжилтийн хэрэгсэл (ШСХ)-д яаралтай хамруулах хэлэлцээрт хүрчээ. Шуурхай санхүүжилтийн хэрэгсэлд төсвийн болон төлбөрийн тэнцлийн яаралтай төлбөрүүдийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 72.3 сая зээлжих тусгай эрх буюу 99 сая ам.долларын санхүүжилт олгох ОУВС-гийн ажлын багийн түвшний хэлэлцээрт хүрэв.

АГААРЫН ТЭЭВРИЙН ОРЛОГО ӨМНӨХ ОНЫХООС 52,4 ХУВИАР БУУРАВ.

- Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого эхний 4 сард 6.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 380.0 (6.1%) сая төгрөгөөр өсжээ. Харин оны эхний 4 сарын орлого 58.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 64.5 (52.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Агаарын тээврээр зорчигчид оны эхний 4 сард давхардсан тоогоор 240.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 161.0 (40.1%) мянган хүнээр цөөрсөн байна. Агаарын тээвээр олон улсад зорчигчид оны эхний 4 сард 132.5 (55.2%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 140.7 (51.5%) мянган хүнээр буурчээ. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 75.8 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 63.7 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 67.1 хувь, Улаанбаатар-Москва чиглэлийн зорчигчид 42.5 хувь, Улаанбаатар-Сөүл чиглэлийн зорчигчид 40.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 5-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 5-р сар 2020 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*